

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГОТОЙ УЯЛДСАН ҮР ДҮНД СУУРИЛСАН 2025 ОНЫ ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН САНАЛ БЭЛТГЭХ ЗААВАР

Агуулга

1. Заавар №1:Хөтөлбөрийн ангиллыг орон нутгийн төсөвт зохистой ашиглах
2. Заавар №2:Үр дүнд суурилсан төсвийн төслийн маягтыг бөглөх

ЗААВАР №1. ХӨТӨЛБӨРИЙН АНГИЛЛЫГ ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ЗОХИСТОЙ АШИГЛАХ

Дорноговь аймгийн сайн туршлага

Монгол Улсын Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам, НҮБХХ-тийн “Монгол Улсад тогтвортой хөгжлийн зорилттой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих” нь төсөл хамтран Дорноговь аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөө болон аймгийн 2024 оны төсвийн төслийг үр дүнд суурилсан арга зүйгээр боловсруулан туршиж байна. Дорноговь аймгийн ИТХ-ын 2023 оны 10 сарын 16-ны өдрийн 14/01 тоот тогтоолоор батлагдсан “Дорноговь аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөө”-д тусгагдсан хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлтүүд нь үр дүнд суурилсан төсөвлөлтийг боловсруулах үндсэн суурь нь болсон.


Жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан зарим арга хэмжээ орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаардаггүй боловч салбарын хууль тогтоомжид аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ болон Засаг дарга нарын хэрэгжүүлэх чиг үүрэг, бүрэн эрхийн хүрээнд хуульчлагдсан байдаг.

Тухайн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад зайлшгүй орон нутаг хувь нэмэр оруулах шаардлага байгааг харгалзан жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан “Төрийн архив албан хэрэг хөтлөлт, Төрийн албаны ерөнхий удирдлага, Үндэсний аюулгүй байдлыг сахин хамгаалах, Хүний эрхийн хэрэгжилтэд хяналт тавих, Авлигатай тэмцэх, Төлбөрийн чадваргүй яллагдагч, сэжигтэнд эрх зүйн туслалцаа үзүүлэх, Цахим засаглал, Нээлттэй Дорноговь, Шүүхийн бие даасан байдлыг хангах, Цагдаа зэрэг хөтөлбөрийн төсөл арга хэмжээнд шаардагдах төсвийг “Гүйцэтгэх засаглалын удирдлага” болон орон нутгийн чиг үүрэгтэй холбогдох бусад хөтөлбөрт нэгтгэн төсөвт тусгаж байсан.

Үр дүнд суурилсан төсөвлөлтийн арга зүйг Дорноговь аймагт туршин нэвтрүүлэх явцад тулгарсан сорилт болон ололт, амжилт:

- ✓ Үр дүнд суурилсан төсөвлөлтийн үндсэн зарчим нь урсгал болон хөрөнгийн зардлыг хөтөлбөрөөр нэгтгэн төлөвлөх юм. Гэвч өнөөгийн практикт хөрөнгө оруулалт болон урсгал зардлыг тусад нь авч үзэн, хамаарах хөтөлбөрт нь нэгтгэж төлөвлөх хангалтгүй байсан. Харин 2024 оны төсөв нь зорилтот үр дүнг хангахад чиглэгдсэн урсгал болон хөрөнгийн зардлыг нэгтгэн төсөвлөсөн нь хөтөлбөрийн төсвийг бүрэн тооцох боломжийг бий болгосон.
- ✓ Өмнө жилүүдэд урсгал болон хөрөнгийн зардлыг нэгтгэн хамаарах хөтөлбөрөөр төлөвлөөгүйгээс 2022 онд нийт төсвийн 90.1 хувийг, 2023 онд 69.6 хувийг “Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөр” –т төлөвлөсөн байна. Энэ нь ТЕЗ-ийн ихэнх зардлыг удирдлагын үйл ажиллагаанд зарцуулдаг мэт харагдуулж байсан бол, төсвийг хамаарах хөтөлбөрийн ангилал руу төлөвлөснөөр “Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөр”-ийн зардал 2023 оноос 4 дахин буурч, 2024 оны аймгийн орон нутгийн төсвийн 9.8 хувь болсон.

Зураг:1 Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөрийн төсөв 2022-2024 он.



- ✓ Орон нутгийн төсвийн хавсралтад тусгагдах хөтөлбөрийн хүрэх үр дүнг “Аймгийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-тэй уялдуулан тодорхойлсон нь ТЕЗ-ын хүрэх үр дүнгийн боловсруулалт сайжрахад нөлөөлж, хөтөлбөрийн төсвийн үр дүнгийн гүйцэтгэлийн тайланг гаргах, хяналт шинжилгээ үнэлгээ хийх боломжийг бүрдүүлсэн.

Орон нутгийн төсөвт “Хөтөлбөр”-ийн ангиллыг зохистой ашиглах

- ✓ Төсвийн тухай хуулийн 31.1” эрхлэх асуудлын хүрээнд хөрөнгө оруулалтын арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийн хэмжээг холбогдох хөтөлбөрт тусгасан байх.” заалтын дагуу орон нутгийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сан, замын сан, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын эх үүсвэрээр хэрэгжих төсөл арга хэмжээ бүрийг үр дүн нь хамаарах хөтөлбөрөөр төлөвлөх;
- ✓ Жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлтийг тодорхойлох мэдээллийн бэлэн байдлыг хангах;
- ✓ Fiscal-д төсвийн санал оруулахдаа урсгал болон хөрөнгийн зардлыг үр дүн нь хамаарах хөтөлбөрийн ангиллыг зөв сонгож оруулах ба төсвийн зарлагын ангиллын “Ангилалдаагүй бусад” гэсэн хэсгийг сонгож оруулахгүй байх;
- ✓ Сангийн сайдын 2023 оны 225 дугаар тушаалаар бүх шатны төсвийн байгууллагад мөрдөгдөх “Хөтөлбөр арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүнг тайлагнах заавар” батлагдсан тул холбогдох, заавар журмыг анхаарах.

Төсвийн зардлын бүртгэлийг сайжруулах зорилгоор Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуульд заасан орон нутгийн чиг үүрэг ба төсвийн хөтөлбөрийн ангилал хоорондын уялдааг Хүснэгт 1-д заасны дагуу хуваарилах

Хүснэгт:1 Орон нутгийн чиг үүрэг хөтөлбөрийн ангиллын уялдаа

Орон нутгийн чиг үүрэг	Хөтөлбөр бүлгийн код	Нэр	Хөтөлбөр код	Хөтөлбөрийн нэр	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх байгууллага
20.1.1.орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлт; 20.1.4.орон нутгийн сан;	70100	Ерөнхийлөгч , хууль тогтоох болон гүйцэтгэх засаглалын удирдлага	70105	Орон нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаа	Аймаг сум, Нийслэл дүүргийн ИТХ,ИТХ-ын ажлын алба, Баг хорооны Иргэдийн нийтийн хурал
20.1.5.орон нутгийн хүний нөөцийн бодлогын төлөвлөлт, хөтөлбөр;			70106	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	аймаг, нийслэл, сум, дүүрэг баг хорооны Засаг дарга,Засаг даргын Тамгын газар, хот, тосгоны захирагчийн алба
20.1.3.орон нутгийн төсөв, албан татвар, төлбөр, хураамж;	70400	Төрийн нийтлэг бусад үйлчилгээ	70429	Санхүүгийн хяналт, дотоод аудит, эрсдэлийн удирдлага	Санхүүгийн хяналт дотоод аудитын алба
20.1.2.орон нутгийн өмчийн удирдлага;			70426	Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх	Орон нутгийн өмчийн газар
			70418	Худалдан авах үйл ажиллагаа	Худалдан авах ажиллагааны газар
20.1.10.орон нутаг дахь нийтийн тээвэр; 20.1.11.суурин газрын замын хөдөлгөөн, авто зогсоол;	71100	Зам тээвэр	71105	Орон нутгийн хяналт зохицуулалт нийтийн тээвэр	Аймаг, нийслэл, сум , дүүргийн Засаг дарга,ЗДТГ, нийтийн тээврийн үйлчилгээ хариуцсан байгууллага, Орон нутгийн АЗЗА-ын байгууллага
20.1.21.орон нутгийн зам, гүүр;			71101	Авто зам	
20.1.19.гал түймэр, үерийн хамгаалалтын байгууламж, суваг шуудуу;	70700	Эрх зүй нийгмийн хэв журам аюулгүй байдал	70708	Гамшгаас урьдчилан сэргийлэх	Аймаг нийслэл сум дүүргийн засаг дарга,,Засаг даргын дэргэдэх зөвлөл
20.1.7.хүн амын ундны болон ахуйн хэрэгцээний усан хангамж;	71500	Барилга хот байгуулалт нийтийн аж ахуй	71506	Суурин газрын усан хангамж	Аймаг нийслэл сум дүүргийн засаг дарга ,хот тохижилт үйлчилгээ хариуцсан байгууллага
20.1.14.нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, ногоон байгууламж;			71502	Хот байгуулалт, тохижилт	Аймаг, нийслэл сум дүүргийн хот тохижилт үйлчилгээний газар орон

20.1.9.орон сууц, нийтийн аж ахуй; 20.1.12.гудамж, талбайн нэр, хаягжуулалт; 20.1.13.хөшөө дурсгалын зохицуулалт; 20.1.17.оршуулгын газрын зохицуулалт;					нутгийн төсвөөс санхүүжих
20.1.20.орон нутгийн цэвэрлэх байгууламж;				71507	
20.1.22.суурин газрын гэрэлтүүлэг;				71508	
20.1.16.хог хаягдлын менежмент;	71400	Хүрээлэн буй орчин	71406	Хүрээлэн буй орчны бохирдол доройтлыг бууруулах хөтөлбөр	БОАЖЯ, аймаг, нийслэл сум ,дүүргийн ЗДТГ
.1.18.төрийн болон орон нутгийн өмчийн боловсрол, эрүүл мэнд, нийгэм, соёлын байгууллагын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар;	71600	Эрүүл мэнд	71602	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	Аймаг нийслэл сум дүүргийн Засаг дарга, түүнд харьяалагдах боловсрол, эрүүл мэнд, нийгэм, соёлын байгууллага
	71700	Соёл урлаг спорт аялал жуулчлал	71701	Биеийн тамир спорт	
			71702	Соёл урлаг	
	71800	Боловсрол	71801	Сургуулийн өмнөх боловсрол	
			71802	Ерөнхий боловсрол	
			71804	Мэргэжлийн боловсрол	
			71806	Насан туршийн болон албан бус	
20.1.6.орон нутгийн үйлдвэрлэл, хүнс, хөдөө аж ахуй; 20.1.23.бэлчээрийн ашиглалт, хамгаалалт.	70800	Хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэр	70801	Мал аж ахуйг хөгжүүлэх хөтөлбөр	Аймаг, нийслэл сум дүүргийн ЗДТГ
			70802	Газар тариаланг хөгжүүлэх хөтөлбөр	
			70803	Хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөтөлбөр	
			70804	Хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөтөлбөр	
20.1.15.орон нутгийн аялал жуулчлалын бодлого, менежмент;	71700	Соёл урлаг спорт аялал жуулчлал	71703	Аялал жуулчлал	Аймаг, нийслэлийн БОАЖ-ын газар, аймаг сумын ЗДТГ

ЗААВАР №2. ҮР ДҮНД СУУРИЛСАН ТӨСВИЙН ТӨСЛИЙН МАЯГТ БӨГЛӨХ

1. Төсвийн саналын хамрах хүрээ

Монгол Улсын Их Хурлын тогтоолоор баталсан “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”, аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх 2025 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэх орон нутгийн 2025 оны төсвийн төсөл, 2026 ба 2027 оны төсвийн төсөөллийг үр дүнд суурилсан арга зүйг баримтлан энэхүү зааврын дагуу боловсруулна. Уг зааврыг Европын холбооны санхүүжилттэй НҮБХХ-ийн “Монгол Улсад ТХЗ-той уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн хүрээнд боловсруулав.

2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн (ТЕЗ) үр дүнд суурилсан төсвийн төслийн маягтыг бөглөх заавар

ТЕЗ-үүд нь хэрэгжүүлэх хөтөлбөрийнхөө 2025 оны төсвийн төслийг үр дүнд суурилсан төсөвлөлтийн арга зүйг ашиглан дараах 5 маягтын дагуу боловсруулж ирүүлнэ. Үүнд:

- **МАЯГТ 1. ҮР ДҮНГИЙН ХҮРЭЭ**
- **МАЯГТ 2. ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮН, ТҮҮНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**
- **МАЯГТ 3. ХӨТӨЛБӨРИЙН ГАРЦ, ТӨСВИЙН ТӨСЛИЙН НЭГТГЭЛ**
- **МАЯГТ 4. ТЕЗ-ИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРИЙН ТӨСВИЙН ТӨСӨЛ**
- **МАЯГТ 5. 2025 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛИЙН ЖАГСААЛТ, ТҮҮНИЙ ТӨСӨВ**

Маягтыг дараах дарааллын дагуу бөглөнө. Үүнд:

- I. Үр дүнд суурилсан төсөвлөлт (ҮДСТ)-ийн үндсэн зарчмын дагуу МАЯГТ 1-ийн үр дүнгийн логик хүрээг эхэлж боловсруулна.
- II. МАЯГТ 2-ын багана 1-10 хүртэл мэдээллийг зааврын дагуу бөглөнө.
- III. МАЯГТ 3-ын багана 1-8 мэдээллийг зааврын дагуу оруулна.
- IV. МАЯГТ 5-ын тухайн онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төслийн жагсаалт, түүний төсвийн мэдээллийг МАЯГТ 3-ын гарцын зорилтот түвшинтэй уялдуулан бөглөнө.
- V. МАЯГТ 4-ийн ТЕЗ-ийн хөтөлбөрийн төсвийн төслийг зааврын дагуу боловсруулна.
- VI. МАЯГТ 3-ын багана 9-11 ба МАЯГТ 2-ын багана 11-13-ыг зааврын дагуу МАЯГТ 4-өөс татаж оруулна.

Маягтуудыг бөглөхдөө дараах зааврыг харна уу.

МАЯГТ 1. ҮР ДҮНГИЙН ХҮРЭЭ

Үр дүнгийн хүрээний хүснэгт нь Үр дүнд суурилсан төсөвлөлтийн гол зарчим болох үр дүнгийн логик уялдааг харуулах зорилготой. Эдийн засаг хөгжлийн сайдын 2022 оны 12 сарын 28-ны өдөр А/167 тоот тушаалаар батлагдсан үр дүнд суурилсан “Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ын дагуу Алсын хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн зорилго, зорилтод үндэслэн Үндэсний, салбарын, ТЕЗ-ийн, хөтөлбөрийн үр дүнг тодорхойлсон. ЭЗХЯ-ны батлагдсан аргачлалын дагуу асуудал, хэрэгцээ, шалтгаан уялдаа холбооны шинжилгээнд тулгуурласан учраас хөтөлбөрийн үр дүн хангагдахад ТЕЗ-ийн, дараа нь салбарын, эцэст нь үндэсний үр дүн бүрэн хангагдах логик хамааралтай байх гол зарчмыг анхаарч үр дүнгийн хүрээг боловсруулна.

Багана 1,2 - “Үндэсний үр дүн” баганад дээрх зарчмын хүрээнд Алсын хараа 2050 урт хугацааны бодлогын баримт бичиг, орон нутгийн чиг үүрэг, эрхлэх асуудлын хүрээнд тодорхойлсон үндэсний үр дүнг бодлогын үндэслэлийн хамт оруулсан.

Багана 3,4 - “Салбарын үр дүн” баганад үр дүнгийн логик хүрээнд тулгуурлах зарчмын дагуу үндэсний үр дүн, орон нутгийн чиг үүрэг, эрхлэх асуудлын хүрээнд тодорхойлсон салбарын үр дүнг Алсын хараа 2050 урт хугацааны бодлогын баримт бичгийн холбогдох заалт, үндэслэлийн хамт оруулсан.

Багана 5,6 – “Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн” баганад үр дүнгийн логик хүрээнд тулгуурлах зарчмын дагуу салбарын үр дүн, орон нутгийн чиг үүрэг, эрхлэх асуудлын хүрээнд тодорхойлсон Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнг МУХТЖҮЧ 2021-2025 баримт бичгийн холбогдох зорилтын дугаар бодлогын үндэслэлийн хамт оруулсан.

Багана 7,8 - “Хөтөлбөрийн үр дүн” баганад ТЕЗ-ийн үр дүнд хамаарах хөтөлбөрийн код, нэрийг сонгож оруулсан. Хэрвээ нэмэлт хөтөлбөрийг сонгох шаардлагатай бол хөтөлбөрийн код ба нэрийг сонгож оруулна.

Багана 9 – “Хөтөлбөрийн үр дүн – Орон нутгийн жилийн төлөвлөгөөнд батлагдсан” баганад Орон нутгийн жилийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөлд тусгагдсан хөтөлбөрийн үр дүнг бичнэ.

Багана 10 – “Хөтөлбөрийн үр дүнгийн код” баганад ТЕЗ-ийн төсвөөр хэрэгжүүлэх хөтөлбөрийн үр дүн бүрийг ялгаатай байдлаар кодлон, бичнэ. Код нь 7 оронтой тооноос бүрдэх ба эхний 5 орон нь хамаарах хөтөлбөрийн код 7XXXX /багана 7/, дараагийн 2 орон нь нэг хөтөлбөрт хамаарах үр дүнг дэс дараалсан байдлаар дугаарласан байна. /7XXXX01- 7XXXX09/.

Багана 11 – “ТЕЗ-ийн төсвөөр хэрэгжүүлэх хөтөлбөрийн үр дүн” баганад сонгогдсон хөтөлбөрөөр хэрэгжүүлэх ТЕЗ-ийн чиг үүрэг, эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Орон нутгийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан хөтөлбөрийн үр дүнг Багана 9-ээс хуулж бичнэ. Хэрэв Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан хөтөлбөрийн үр дүнд тухайн ТЕЗ хувь нэмэр оруулах үүрэгтэй ч, эрхлэх асуудлын хүрээнд бүрэн шийдвэрлэх боломжгүй, тухайн үр дүн нь хэд хэдэн ТЕЗ-ийн хэрэгжүүлэх үр дүнгээс хамааралтай бол хөтөлбөрийн үр дүнг дахин тодорхойлж бичнэ. Мөн “Орон нутгийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-нд тусгагдаагүй хөтөлбөрийн үр дүнг Эдийн засаг хөгжлийн сайдын 2023 оны А/26 тоот тушаалаар батлагдсан

үр дүнд суурилсан “Аймаг, нийслэл хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ын дагуу асуудал хариуцсан бодлогын мэргэжилтэн хөтөлбөрийн үр дүнг тодорхойлж маягтад тусгана.

МАЯГТ 2. ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮН, ТҮҮНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Аймаг нийслэл, сум дүүргийн төсөв баталсан ИТХ-ын тогтоолын Монгол Улсын 2025 оны төсвийн тухайн хуулийн Хавсрал 1-ээр батлагдах ТЕЗ-ийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн саналыг бэлтгэхдээ Маягт 2 хүснэгтийг ашиглана. Маягт 2 нь хөтөлбөрөөр хэрэгжүүлэх үр дүн, түүний төсөвт өртгийг дунд хугацаагаар харуулна.

Багана 1,2 – “Хөтөлбөрийн код” ба “Хөтөлбөрийн нэр” баганууд Маягт 1-ийн багана 7 ба 8-аас автоматаар татагдаж бөглөгдөнө.

Багана 3,4 – “Хөтөлбөрийн үр дүнгийн код” ба “ТЕЗ-ийн төсвөөр хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүн” баганууд Маягт 1-ийн багана 10 ба 11-аас автоматаар татагдаж бөглөгдөнө.

Багана 5,6,7 – “Хөтөлбөрийн үр дүнгийн ШҮ-ийн код” ба “Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт” баганад хөтөлбөрийн үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлтийн код, тодорхойлолт, хэмжих нэгжийг оруулна.

- 3) Үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн код
- 4) Үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт
- 5) Шалгуур үзүүлэлтийн хэмжих нэгжийг оруулна.

5-р баганад Шалгуур үзүүлэлтийн кодыг гараас бичиж оруулна. Код нь 9 оронтой тооноос бүрдэх ба эхний 7 орон нь хамаарах Хөтөлбөрийн үр дүнгийн код /багана 3/, дараагийн 2 орон нь нэг хөтөлбөрийн үр дүнд хамаарах үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг дэс дараалсан байдлаар дугаарласан байна. /7XXXXX0X01- 7XXXXX0X09/.

6-р баганад Шалгуур үзүүлэлтийг оруулна. Тухайн үр дүнгийн гүйцэтгэлийг хэмжих үзүүлэлтийг тодорхойлно.

7-р баганад шалгуур үзүүлэлтийн хэмжих нэгжийг оруулна. Тухайлбал хувь, тоо, индекс, ээлж зэрэг хэмжигдэхүүн байна.

Багана 8,9,10,11,12 – “Шалгуур үзүүлэлтийн хүрээ” баганад үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн утгыг оруулна. Үүнд:

- Багана 8 - Шалгуур үзүүлэлтийн суурь он
- Багана 9 - Шалгуур үзүүлэлтийн суурь түвшин
- Багана 10,11,12 - Шалгуур үзүүлэлтийн “Зорилтот түвшин”-г оруулна.

8-р баганад шалгуур үзүүлэлтийг хэмжсэн “Суурь он”-ыг оруулна. Үзүүлэлт бүрийн хувьд хэмжсэн суурь он ялгаатай байж болно.

9-р баганад суурь онд үзүүлэлт нь ямар хэмжээтэй байсныг оруулна. Суурь түвшин нь аль болох үнэн зөв, найдвартай эх сурвалжийн мэдээлэлд үндэслэсэн боломжит хамгийн сүүлийн утга, үзүүлэлт байна.

10-р баганад төсвийн төлөвлөлт хийж буй он буюу 2025 оны зорилтыг тодорхойлно.

11 болон 12-р баганад 2025 оны зорилтот түвшнийг сайжруулахаар төлөвлөнө. Гэхдээ гадаад ба дотоод орчны нөхцөл байдлаас шалтгаалан тухайн үзүүлэлт буурах хандлагатай бол бодит тоон мэдээллийг оруулна.

Багана 13, 14, 15 – “Төсвийн санал” баганад төсвийн төсөл, төсөөллийн тоон мэдээллийг оруулна. Үүнд:

- 13) 2025 оны төсвийн төсөл
- 14) 2026 оны төсөөлөл
- 15) 2027 оны төсөөллийг оруулна.

13-р баганад “2025 оны төсвийн төсөл” баганын эхний мөрд Хөтөлбөрийн төсвийн саналын нийт дүнг Маягт 3-аас татна.

14 ба 15-р баганад тухайн хөтөлбөрийн төсвийн төсөөллийг оруулна. Төсвийн төсөл дунд хугацаагаар байх ёстой учраас 2026, 2027 оны төсөөллийг урьдчилан тооцож оруулна. БШУЯ-ны төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлдэг хөтөлбөрүүдийн хувьд төсвийн төсөөллийн урьдчилсан тооцоолол хийхдээ “илтгэгчийн жинг сүүл рүү хуваарилах-хандлагаар тохируулсан” (Exponential smoothing-adjusted Holt) загвар ашиглана. Ийм маягаар салбар бүр урьдчилсан тооцоолол хийж (projection or forecasting), төсөөллийг боловсруулна.

Багана 16 - “Мэдээллийн эх сурвалж” баганад шалгуур үзүүлэлтийг тооцох мэдээллийн эх сурвалжийг дэлгэрэнгүй тайлбарлаж оруулна.

МАЯГТ 3. ХӨТӨЛБӨРИЙН ГАРЦ, ТӨСВИЙН ТӨСЛИЙН НЭГТГЭЛ

Хөтөлбөрийн нэр, кодыг сонгон, тухайн хөтөлбөрт хамаарах гарц, түүний шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшний тоон мэдээллийг төсөвт өртгийн хамт харуулна. “Хөтөлбөрийн гарц” гэж хөтөлбөрийн үр дүнг хангахад чиглэсэн төрийн байгууллага болон бусад этгээдээс нийлүүлэх эцсийн бүтээгдэхүүн, үйлчилгээ буюу арга хэмжээний багцыг ойлгоно.

Багана 1,2 – “Хөтөлбөрийн код” ба “Хөтөлбөрийн нэр” баганууд Маягт 2-ийн багана 1 ба 2-аас автоматаар татагдаж бөглөгдөнө.

Багана 3,4 – “Гарцын код” ба “Гарцын нэр” баганад хөтөлбөрт хамааралтай гарцын код ба нэрийг сонгож оруулна. Хөтөлбөр бүрд хамаарах гарцын код, гарцын нэрийг “Гарц болон ШҮ” хуудаснаас мөн ҮДСТ-ийн удирдамжийн Хавсралт 02-д өгөгдсөн гарцуудаас харна уу. Хэрвээ шинээр гарц нэмэх шаардлагатай бол шинэ гарцын код, гарцын нэр, гарцын ШҮ код, гарцын шалгуур үзүүлэлтийг “Гарц болон ШҮ” хуудсанд нэмж оруулна. Ингэснээр баганын сонголтын цэсэд бүртгэгдэж сонгох боломжтой болохыг анхаарна уу.

Багана 4,5 – “Гарцын ШҮ код” ба “Гарцын шалгуур үзүүлэлт” баганад “Гарц болон ШҮ” хуудаснаас сонгон оруулна.

Багана 7,8,9,10 – Гарцын шалгуур үзүүлэлтийн суурь ба зорилтот түвшнийг тодорхойлохдоо тухайн төсвийн жилд хүрэхээр тодорхойлсон үр дүнгийн зорилтот түвшнийг хангаж буй эсэхийг нягтална. Ингэхдээ гарцыг 100 хувь хэрэгжүүлэхэд хөтөлбөрийн үр дүнгийн зорилтот түвшин бүрэн хангагдах эсэхийг нягтлах замаар логик уялдаа холбоог шалгана.

Багана 11,12,13 - “Төсвийн төсөл 2025 он” хэсэг нь “МАЯГТ: 4”-ийн тооцооллоос татаж оруулна.

МАЯГТ 4. ТЕЗ-ИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРИЙН ТӨСВИЙН ТӨСӨЛ

ТЕЗ-ийн хөтөлбөр, гарц, хэрэгжүүлэгч байгууллага, зардлын зориулалт, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлын уялдаа холбоог харуулах, нэгтгэлийг дүгнэх зорилгоор энэхүү маягтыг боловсруулна.

Багана 1, 2 – “Хөтөлбөрийн код” ба “Хөтөлбөрийн нэр” баганад Хөтөлбөрийн холбогдох код, нэрийг сонгож оруулна.

Багана 3, 4 - “Гарцын код” ба “Гарцын нэр” баганад “Гарц болон ШҮ” хуудаснаас эсвэл ҮДСТ-ийн удирдамжийн Хавсралт 01-д буй хөтөлбөрт хамаарах гарцуудаас сонгон гарцын холбогдох код, нэрийг оруулна.

Багана 5, 6 – “Байгууллагын код” ба “Байгууллага” баганад тухайн хөтөлбөр, гарцын үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах байгууллагын код, нэрийг оруулна. Байгууллагын код ба нэр нь төсвийн Fiscal программд оруулсан код, нэршилтэй ижил байна.

Багана 7, 8 – “Зориулалт, арга хэмжээний код” ба “Зориулалт” баганад тухайн гарцыг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагааны зардлын зориулалтын код, зориулалтын нэрийг оруулна. Зардлын зориулалт нь тухайн хөтөлбөр, гарцыг хангахад чиглэсэн байх ба дэлгэрэнгүй зориулалт, арга хэмжээний хэрэглээний тайлбарыг ҮДСТ-ийн удирдамжийн Хавсралт 01 Хөтөлбөрийн тодорхойлолт-с харна уу.

Багана 9, 10 – “Урсгал” ба “Хөрөнгө оруулалт” тухайн зардлын зориулалтаас хамааран урсгал зардал бол 9-р баганад, хөрөнгө оруулалтын зардлыг 10-р баганад Маягт 5-н 14-р баганын дүнгээс татаж оруулна. Зардлын дүнг мянган төгрөгөөр тусгана.

МАЯГТ 5. 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛИЙН ЖАГСААЛТ, ТҮҮНИЙ ТӨСӨВ

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 31.1” Эрхлэх асуудлын хүрээнд хөрөнгө оруулалтын арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийн хэмжээг холбогдох хөтөлбөрт тусгасан байх.” заалтын дагуу улс орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан, замын сан, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын эх үүсвэр болон төсөл хөтөлбөр, концесс, их засварын хөрөнгөөр шинээр, болон шилжин хэрэгжих төсөл бүрийг хамаарах хөтөлбөр, гарцын ангиллаар төлөвлөнө.

Багана 1 – “№” баганад Хөрөнгө оруулалтын төслийн дэс дараалал дугаарыг оруулна.

Багана 2,3 - “Хөтөлбөрийн код” ба “Хөтөлбөрийн нэр” баганад ҮДСТ-ийн удирдамжийн Хавсралт 02-д Хөтөлбөрийн тодорхойлолтод тусгагдсан хөтөлбөрийн нэр, кодоос сонгож оруулна.

Багана 4,5 – “Гарцын код” ба “Гарцын нэр” баганад ҮДСТ-ийн удирдамжийн Хавсралт 02-д Хөтөлбөрийн тодорхойлолтод тусгагдсан гарцын нэр, кодоос сонгож оруулна.

Багана 6 – “Төлөв” баганад төлөвлөж байгаа төсөл нь тухайн жилд шинээр хэрэгжиж эхэлж байгаа бол “шинэ”, өмнө жилээс шилжин хэрэгжиж байгаа бол “шилжих” гэдгийг сонгож оруулна.

Багана 7 – “Төрөл” баганад хөрөнгө оруулалтын төсөл нь барилга байгууламж, тоног төхөөрөмж, их засварын аль төрөлд хамаарахыг сонгож оруулна.

Багана 8 – “Төслийн код” баганад хөрөнгө оруулалтын төслийн pims.publicinvestment.gov.mn системд бүртгэгдсэн кодыг бичнэ.

Багана 9 – “Төслийн нэр, хүчин чадал, байршил” баганад улсын болон орон нутгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан төслийг бичнэ.

Багана 10,11 – “Хэрэгжүүлэх хугацаа” баганад төсөл хэрэгжүүлэх хугацааг тодорхойлж бичнэ.

Багана 12 - “Анхны төсөвт өртөг” баганад мэргэжлийн байгууллагаар баталгаажсан, ТЭЗҮ-д тусгагдсан хөрөнгө оруулалтын төслийн анхны төсөвт өртгийг бичнэ.

Багана 13- “20XX оны төсөвт өртөг” баганад ТЭЗҮ өөрчлөгдсөнөөс анхны төсөвт өртөг өөрчлөгдсөн бол өөрчлөлт хийгдсэн, баталгаажсан дүнг бичнэ.

Багана 14- “Санхүүжих дүн” баганад 2025 онд санхүүжүүлэх төсвийн хэмжээг бичнэ.

Хөрөнгө оруулалтын төслийг холбогдох хөтөлбөрт хуваарилах

Хөрөнгө оруулалтын төсөл нэг бүрийг буюу улсын төсөв болон төр хувийн хэвшлийн түншлэл (концесс)-ээр санхүүжүүлэх шинэ болон шилжих барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмжийг холбогдох хөтөлбөрт дараах байдлаар хуваарилна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр салбарын хөрөнгө оруулалтын төслийг бүртгэх хөтөлбөр

#	Код	Хөтөлбөрийн нэр	Хөрөнгө оруулалтын төсөл
1	70801	Мал аж ахуйг хөгжүүлэх хөтөлбөр	Малчид болон орон нутгийн хөгжлийг дэмжих төв, сум, аймаг, нийслэлийн мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуйн лабораторийн шинжилгээний барилга, мал эмнэлгийн хорио цээр, ариутгал халдваргүйжилтийн хяналтын цэг байгуулах, мал эмнэлгийн тарилга хийхэд зориулагдсан малын ангилалтын автомат хашаа, эмийн болон биологийн бүтээгдэхүүнийг хадгалах эмнэлгийн зориулалттай хөргүүр, бэлчээрийн усан хангамжийн хүрээнд инженерийн хийцтэй худаг гаргах, ноос хяргах, боловсруулах тоног төхөөрөмж, малын бүртгэлжүүлэлт, ялган тэмдэглэх, отрын бүс нутгийн захиргааны ХАА-н үйлдвэрлэлийн төв, мал аж ахуйг хөгжүүлэхтэй холбоотой барилга, их засвар, тоног төхөөрөмж
2	70802	Газар тариаланг хөгжүүлэх хөтөлбөр	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн кластер байгуулах, үр тариа, хүнс, ногоо хадгалах агуулахын барилга, малын тэжээлийн төсөл, газар тариалангийн услалтын систем, өвөл зуны хүлэмжийн цогцолбор бүхий агро аж ахуй байгуулах, тариалангийн талбайд ойн зурвас байгуулах, тариалангийн талбайн хашаажуулалт, газар тариаланг хөгжүүлэхтэй холбоотой барилга, их засвар, тоног төхөөрөмж
3	70803	Хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөтөлбөр	Хөдөө аж ахуйн салбарт цөмийн технологийг ашиглах зорилгоор ариутгал, халдваргүйжүүлэлтийн тоног төхөөрөмж, цөцгийн тос үйлдвэрлэх сүүний ферм, бяслагийн үйлдвэр, хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхтэй холбоотой барилга, их засвар, тоног төхөөрөмж
4	70804	Хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөтөлбөр	Үйлдвэр технологийн паркийн бүтээн байгуулалт, хөнгөн үйлдвэрийн түүхий эдийн төв, малын гаралтай түүхий эдийн цэвэрлэх байгууламж, дэд бүтэц, түүний бүтээн байгуулалт, хөнгөн үйлдвэрийг хөгжүүлэхтэй холбоотой барилга, их засвар, тоног төхөөрөмж

5	72101	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга, загвар хоршоод, бизнес инкубатор төв, орон нутгийн хөгжлийг дэмжих барилга, бичил, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжихтэй холбоотой барилга, их засвар, тоног төхөөрөмж, зураг төсөл
6	71704	Хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн бодлого, удирдлага	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэхтэй холбоотой цогц төсөл, барилга, их засвар, тоног төхөөрөмж, орон нутаг дахь хүнс, хөдөө аж ахуйн газрын барилга, их засвар, тоног төхөөрөмж, зураг төсөл

Эрчим хүчний салбарын хөрөнгө оруулалтын төслийг бүртгэх хөтөлбөр

№	Код	Хөтөлбөрийн нэр	Хөрөнгө оруулалтын төсөл
1	70901	Цахилгаан эрчим хүч хөтөлбөр	Цахилгаан дамжуулалт, түгээх шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэл, цахилгаан эх үүсвэр, хангамжийг нэмэгдүүлэх дэд бүтцийн бүтээн байгуулалт болон сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэхтэй холбоотой барилга байгууламж, засвар, тоног төхөөрөмж
2	709xx	Дулааны эрчим хүч хөтөлбөр	Дулаан дамжуулалт, түгээх шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэл, дулааны эх үүсвэр, хангамжийг нэмэгдүүлэх дэд бүтцийн бүтээн байгуулалттай холбоотой хөрөнгө оруулалтын барилга, их засвар, тоног төхөөрөмж
3	70906	Эрчим хүчний бодлого, удирдлага хөтөлбөр	Эрчим хүчний яамны барилга, их засвар, тоног төхөөрөмж

Байгаль орчин, Аялал жуулчлал салбарын хөрөнгө оруулалтын төслийг бүртгэх хөтөлбөр

№	Код	Хөтөлбөрийн нэр	Хөтөлбөрийн тодорхойлолт
1	71411	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	Байгаль орчны яам, Аймаг нийслэлийн Байгаль орчны газрын барилга, их засвар, тоног төхөөрөмж
2	71408	Цаг уур орчны шинжилгээ хөтөлбөр	Ус, цаг уурын судалгаа шинжилгээтэй холбогдсон барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж
3	71406	Хүрээлэн буй орчны бохирдол доройтлыг бууруулах хөтөлбөр	Агаарын бохирдлыг бууруулах, хог хаягдал цэвэрлэх, цуглуулах, ангилан ялгах, зайлуулах, устгах, дахин боловсруулах цэгт хүргэх, хог хаягдлыг дахин боловсруулахтай холбогдсон барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж
4	71405	Тусгай хамгаалалттай газар	Тусгай хамгаалалттай газар нутгийн үйл ажиллагаатай холбогдсон барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж

		нутгийн хамгаалалт хөтөлбөр	
5	71412	Хүрээлэн буй орчны судалгаа шинжилгээ хөтөлбөр	Байгаль орчны бохирдол доройтлоос урьдчилан сэргийлэх, бохирдлыг бууруулах, саармагжуулах чиглэлээр судалгаа шинжилгээтэй холбогдсон барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж
6	714XX	Усны нөөцийн хамгаалал, ашиглалт, нөхөн сэргээлт хөтөлбөр	Усны нөөц түүний сав газрыг хамгаалах, усны эх үүсвэрийг нэмэгдүүлэх хөв цөөрөм байгуулахтай холбоотой барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж
7	714XX	Ойн нөөцийн хамгаалал нөхөн сэргээлт хөтөлбөр	Ойжуулах, нөхөн сэргээх, ойн хяналтыг хэрэгжүүлэх, ойн судалгаа шинжилгээ хийхтэй холбогдсон барилга байгууламж, их засвар, техник тоног төхөөрөмж
8	714XX	Газрын нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх хөтөлбөр	Газрын доройтлыг бууруулах, цөлжилт элсний нүүдлээс хамгаалах, эвдэрсэн газрыг нөхөн сэргээх, малын бэлчээрийг хашиж хамгаалах, ургамлын нөмрөгийг нөхөн сэргээх зэрэг газрын нөөцийг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбогдсон барилга байгууламж, их засвар, техник тоног төхөөрөмж
9	714XX	Байгалийн ургамлын нөөцийн хамгаалал, нөхөн сэргээх хөтөлбөр	Ургамлын нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, ховор ургамлыг тарималжуулахтай холбогдсон барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж
10	714XX	Амьтны нөөцийн хамгаалал, нөхөн сэргээлт хөтөлбөр	Амьтан хамгаалах, өсгөн үржүүлэх, тогтвортой ашиглах, устаж болзошгүй амьтдыг сэргээн нутагшуулах, зориудаар өсгөн үржүүлэхтэй холбогдсон барилга байгууламж, тоног төхөөрөмж
11	714XX	Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах хөтөлбөр	Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, хүлэмжийн хийг бууруулахад чиглэсэн барилга байгууламж, их засвар, техник тоног төхөөрөмж
12	714XX	Байгалийн ургамал амьтны генетик нөөц хөтөлбөр	Байгалын ургамал, амьтны генетик нөөцийг судлах, ашиглахтай болбоотой, барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж
13	71703	Аялал жуулчлал хөтөлбөр	Аялал жуулчлалыг хөгжүүлэхэд чиглэсэн барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж

Соёл урлагийн салбарын хөрөнгө оруулалтын төслийг бүртгэх хөтөлбөр

#	Код	Хөтөлбөрийн нэр	Хөрөнгө оруулалтын төсөл
1	71702	Соёл урлаг	Үндэсний болон орон нутгийн театр, чуулга хэмжээний чуулга, Үндэсний болон орон нутгийн номын сан, Аймаг, орон нутаг дахь соёлын төв, кино урлаг, Үндэсний болон орон нутгийн музей зэрэг соёл урлагийн байгууллага, байгууламжтай холбоотой барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж
2	717XX	Соёлын өв	Соёлын өвийн төв, Соёлын дурсгалт газар, Соёлын өвийн хамгаалалтын захиргааны байгууллага /ЗЦХЗБ/, Төрийн хамгаалалттай тахилгат газар нутаг /ТХТГНХЗ/-тай холбоотой барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж
3	717XX	Соёлын бүтээлч үйлдвэрлэл	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих холбоотой барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж
4	71704	Соёлын бодлого, удирдлага	Соёлын яамны барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж

ЗЦХЗБ*-зургийн цогцолборыг хамгаалах захиргааны байгууллага

ТХТГНХЗ**-түүнийг хүрээлсэн тахилгат газар нутгийн хамгаалалтын захиргаа

Биеийн тамир, спортын салбарын хөрөнгө оруулалтын төслийг бүртгэх хөтөлбөр

#	Код	Хөтөлбөрийн нэр	Хөрөнгө оруулалтын төсөл
1	71707	Биеийн тамир, спорт	Биеийн тамир, спортын улсын хороо, Аймаг, нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын газар, Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төв, Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв зэрэг биеийн тамир спорттой холбоотой барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж
2	71708	Биеийн тамир, спортын бодлого удирдлага	Биеийн тамир, спортын улсын хорооны барилга, их засвар, тоног төхөөрөмж

Боловсрол, шинжлэх ухааны салбарын хөрөнгө оруулалтын төслийг бүртгэх хөтөлбөр

#	Код	Хөтөлбөрийн нэр	Хөрөнгө оруулалтын төсөл
1	71801	Сургуулийн өмнөх боловсрол	Цэцэрлэгийн барилга, их засвар, тоног төхөөрөмж

2	71802	Ерөнхий боловсрол	Сургууль, дотуур байрны барилга, их засвар, тоног төхөөрөмж
3	71803	Дээд боловсрол	Их дээд, сургууль, дотуур байрны барилга, их засвар, тоног төхөөрөмж
4	71804	Мэргэжлийн боловсрол	Мэргэжлийн болон техникийн боловсролын сургууль, дотуур байрны барилга, их засвар, тоног төхөөрөмж
5	71805	Шинжлэх ухаан, технологи	Шинжлэх ухааны Академи, ШУТС-ийн харьяа судалгааны хүрээлэн, төвийн барилга, их засвар, тоног төхөөрөмж
6	71806	Насан туршийн боловсрол	Насан туршийн суралцахуйн төвийн барилга, их засвар, тоног төхөөрөмж
7	71808	Боловсрол, ШУ-ны бодлого удирдлага	Боловсрол, шинжлэх ухааны яамны барилга, их засвар, тоног төхөөрөмж
8	71809	Боловсролын судалгаа шинжилгээ, боловсрол, ШУ-ны мэдээллийн технологи	Боловсролын салбарын мэдээллийн технологийн нэгдсэн сүлжээ, дэд бүтцийн барилга, их засвар, тоног төхөөрөмж, программ хангамж.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хөрөнгө оруулалтын төслийг бүртгэх хөтөлбөр

#	Код	Хөтөлбөрийн нэр	Хөрөнгө оруулалтын төсөл
1	71901	Нийгмийн даатгал	Нийгмийн даатгалын газар, хэлтэс, агентлагийн барилга байгууламж, газар худалдан авах, их засвар, тоног төхөөрөмж, нийгмийн даатгалын мэдээллийн технологийн нэгдсэн сүлжээ, программ хангамж, хөгжүүлэлт
2	71902	Нийгмийн халамж	Нийгмийн халамжийн газар, хэлтэс, ахмадын төрөлжсөн асрамжийн газрын барилга байгууламж, газар худалдан авах, их засвар, тоног төхөөрөмж, машин, нийгмийн халамжийн мэдээллийн технологийн нэгдсэн сүлжээ, программ хангамж, хөгжүүлэлт
3	71903	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын бодлого удирдлага	ХНХЯ-ны барилгын их засвар, машин, тоног төхөөрөмж
4	721XX	Хөдөлмөр	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв, хөдөлмөрийн газар, хэлтсийн барилга байгууламж, газар худалдан авах, их засвар, тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн нэгдсэн сүлжээ, программ хангамж, хөгжүүлэлт
5	72206	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, хамгаалал	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөгжлийн төв, нөхөн сэргээх, протез, ортопед, тусгай хэрэгслийн үйлдвэрлэл, сургалтын төв, ХБХүүхдийн нөхөн сэргээх, сургалт, хөгжлийн төвийн барилга байгууламж, газар худалдан авах, их засвар, машин, тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн нэгдсэн сүлжээ, программ хангамж, хөгжүүлэлт

6	722XX	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгаалал	Хүүхэд, гэр бүл (залуучууд, ахмад, иргэд)-ийн хөгжлийн төв, хүүхдийн зуслан, хүүхдийн төрөлжсөн асрамжийн барилга байгууламж, их засвар, машин, тоног төхөөрөмж, хүүхэд, гэр бүлийн мэдээллийн технологийн нэгдсэн сүлжээ, программ хангамж, хөгжүүлэлт
7	72208	Ахмад настны хөгжил, хамгаалал	Ахмадын төв, өргөө, ордон, сувилал, барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж, ахмадын хөгжил, хамгааллын мэдээллийн технологийн нэгдсэн сүлжээ, программ хангамж, хөгжүүлэлт

Зам, тээврийн хөгжлийн салбарын хөрөнгө оруулалтын төслийг бүртгэх хөтөлбөр

#	Код	Хөтөлбөрийн нэр	Хөрөнгө оруулалтын төсөл
1	71101	Авто зам	Авто зам, дугуйн зам, авто зогсоол, гүүр шинээр барих, өргөтгөх, засварлах, арчлах, тэмдэг, тэмдэглэгээ хийх болон авто замтай холбогдсон зураг төсөв
2	71102	Усан тээвэр	Усан замын тээврийн хэрэгсэл, засварлах, арчлах, тэмдэг, тэмдэглэгээ хийх, усан замын зорчигч, ачаа тээвэрлэлтийн үйлчилгээний төвийн барилга байгууламж, шинэчлэл, засвар, тохижилт, тоног төхөөрөмж
3	71103	Төмөр зам	Төмөр замын тээврийн хэрэгсэл, төмөр замын шинээр барих, өргөтгөх, засварлах, арчлах, тэмдэг, тэмдэглэгээ хийх, төмөр замын зорчигч, ачаа тээвэрлэлтийн үйлчилгээний төвийн барилга байгууламж, шинэчлэл, засвар, тохижилт, тоног төхөөрөмж
4	71104	Агаарын тээвэр	Агаарын тээврийн хэрэгсэл, нисэх буудлын барилга байгууламж, өргөтгөл, агаарын зорчигч тээврийн үйлчилгээний төвийн барилга байгууламж, шинэчлэл, засвар, тохижилт, тоног төхөөрөмж
5	71105	Авто тээврийн хяналт, зохицуулалт, үйлчилгээ, нийтийн тээвэр	Нийтийн тээврийн хэрэгсэл, автобусны буудлын барилга байгууламж, шинэчлэл, засвар, тохижилт, тоног төхөөрөмж
7	71107	Зам, тээврийн бодлого удирдлага	Зам, тээврийн яамны барилга, их засвар, тоног төхөөрөмж

Орон нутгийн хөрөнгө оруулалтын төслийг бүртгэх хөтөлбөр

#	Код	Хөтөлбөрийн нэр	Хөрөнгө оруулалтын төсөл
1	70105	Орон нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаа	Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын ажлын албаны барилга, их засвар, тоног төхөөрөмж

2	70106	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, хот, тосгоны захирагчийн алба, баг хорооны барилга, их засвар, тоног төхөөрөмж
3	70429	Санхүүгийн хяналт, дотоод аудит, эрсдэлийн удирдлага	Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны барилга, их засвар, тоног төхөөрөмж
4	70426	Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх	Орон нутгийн өмчийн барилга, байгууламж, их засвар барилга, тоног төхөөрөмж
5	70418	Худалдан авах үйл ажиллагаа	Худалдан авах ажиллагааг дэмжих техник тоног төхөөрөмж
6	71105	Орон нутгийн хяналт зохицуулалт нийтийн тээвэр	Хүн амын нийтийн тээврийн үйлчилгээг бий болгох сайжруулах хяналт тавихад шаардлагатай их засвар, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, барилга байгууламж
7	71101	Авто зам	Зам гүүр, замын байгууламжийн засвар, арчлалт, зам гүүр, замын байгууламжийг шинээр барих, тэмдэг, тэмдэглэгээ хийх зэрэг авто замтай холбогдсон хөрөнгө оруулалтын төсөл
8	70708	Гамшгаас урьдчилан сэргийлэх	Гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хор уршгийг арилгах гамшиг тохиолдсон үед хойшлуулшгүй сэргээн босгоход чиглэсэн хөрөнгө оруулалтын төсөл
9	70709	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор ашиглах техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, барилга, байгууламж
10	71506	Суурин газрын усан хангамж	Ус олборлох, цэвэрлэх, дамжуулах зориулалт бүхий шугам сүлжээ барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж
11	71502	Хот байгуулалт, тохижилт	Хот байгуулалтын ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөний дагуу улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх хот байгуулалт, тохижилт, үйлчилгээтэй холбогдсон нийтийн эзэмшлийн барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж
12	71507	Ариун цэврийн байгууламж	Ариун цэврийн байгууламжтай холбогдсон барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж
13	71508	Гудамжны гэрэлтүүлэг	Нийтийн эзэмшлийн гудамж талбай, гэр хорооллын гудамжны гэрэлтүүлэгтэй холбогдсон барилга байгууламж их засвар хийх, тоног төхөөрөмж